

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/76/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ЭМДС</i>	<i>Эрүүл мэндийн даатгалын сан</i>
<i>НБББББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
<i>ЭМДҮЗ</i>	<i>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл</i>
<i>ЭЭС</i>	<i>Эмийн эргэлтийн сан</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
/төгрөгөөр/.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	11
3.АУДИТЫН ТАЙЛАН	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж:	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
.....	
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	19

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021-02-25 № 2/124
танай _____ -ны № _____ -т

ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ЭМЧ М.ХӨХНОХОЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар үр дүн, хэрэгжилт, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайлан дахь өр төлбөр болон эм ороох боох материалын үлдэгдлийн тоо мэдээлэл бодит бус, эм болон шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020626

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДВААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,846,739</u>	<u>43,484,167.08</u>
33	АВЛАГА	962,400	2,301,351.58
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	71,400	9,605.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	591,400
335	Бусад авлага	891,000	1,700,346
3351	Байгууллагаас авах авлага	-	808,346
3352	Хувь хүмүүсээс авах авлага	891,000	892,000
35	БАРАА МАТЕРИАЛ	27,884,339	41,182,815.50
351	Түүхий эд материал	-	9,150,026.50
35130	Эм боох материал	-	9,150,026.50
354	Хангамжийн материал	27,884,339	32,032,789
35410	Бичиг хэргийн материал	-	34,650
35420	Аж ахуйн материал	26,274,339	31,314,839
35440	Түлш, шатах тослох материал	1,376,000	200,000
35460	Хүнсний материал	234,000	483,300
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>319,282,254.63</u>	<u>341,071,952.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	319,282,254.63	341,071,952.63
392	Биет хөрөнгө	303,082,604.63	324,963,702.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	259,032,109.06	259,032,109.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,405,710.00)	(21,578,671.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,214,222.00	40,214,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,372,571.43)	(22,475,841.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,512,056	154,527,420
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,608,581)	(91,439,505.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,218,132	18,568,132
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,507,052)	(11,928,162.04)
39217	Ном	-	44,000
393	Биет бус хөрөнгө	16,199,650	16,108,249.96
39301	Программ хангамж	732,000	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(366,400)	(457,800.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,834,050	15,834,050
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>348,128,993.63</u>	<u>384,556,119.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,765,100</u>	<u>2,232,919.80</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,765,100	2,232,919.80
413	Өглөг	1,765,100	2,232,919.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	382,938.00
4136	Бусад өглөг	1,765,100	1,849,981.80
41361	Байгууллагад төлөх өглөг	1,765,100	1,849,981.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>346,363,893.63</u>	<u>382,323,199.91</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	346,363,893.63	382,323,199.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,439,640	191,439,640
51101	Өмч: - төрийн	191,439,640	191,439,640
512	Хуримтлагдсан үр дүн	(123,144,448.43)	(87,185,142.15)
51210	Өмнөх үеийн үр дүн	(123,144,448.43)	(123,144,448.43)
51220	Тайлант үеийн үр дүн	-	35,959,306.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,068,702.06	278,068,702.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	348,128,993.63	384,556,119.71

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	365,872,462	449,121,804
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,264,022	57,225,189
120	Нийтлэг татварын бус орлого	5,264,022	57,225,189
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,264,022	57,225,189
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,469,800	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,794,222	57,225,189
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	360,608,440	391,896,615
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,176,400	339,952,100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,176,400	339,952,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,385,900	11,802,875
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,385,900	11,802,875
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,098,800	22,172,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,098,800	22,172,100
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,947,340	17,969,540
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,947,340	17,969,540
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	382,693,449.56	413,162,497.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,693,449.56	413,162,497.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,693,449.56	412,229,877.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,882,800	258,009,561
210101	Үндсэн цалин	151,659,000	181,238,134
210102	Нэмэгдэл	55,501,800	51,726,064
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000	4,769,000
210104	Урамшуулал	12,178,000	20,276,363
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,039,000	33,592,482.42
210201	Тэтгэврийн даатгал	19,043,600	23,631,812.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,248,800	2,580,095.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799,100	2,064,076.49
210204	Ажилгүйдлийн даатгал	449,800	481,063.42

210205	Эрүүл мэндийн даатгал	4,497,700	4,835,434.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,954,220	22,171,323
210301	Гэрэл, цахилгаан	1,917,000	1,968,653
210302	Түлш, халаалт	11,962,820	20,202,670
210303	Цэвэр, бохир ус	74,400	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,002,400.20	24,366,010
210401	Бичиг хэрэг	2,300,000	3,137,450
210402	Тээвэр, шатахуун	18,202,400.20	16,760,660
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	1,967,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	2,500,400
2105	Нормативт зардал	47,055,761.40	40,883,367
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,411,578	32,959,107
210502	Хоол, хүнс	7,031,133	7,239,760
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,613,050	684,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	952,600	450,000
210604	Урсгал засвар	952,600	450,000
2107	Томилолт, зочны зардал	1,400,000	350,000
210702	Дотоод албан томилолт	1,400,000	350,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,745,465.40	1,757,818.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,545,465.40	1,137,818.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	131,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	124,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000	165,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,661,202.56	30,649,316.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,979,193	4,029,650
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,682,009.56	26,619,666
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	932,620
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	70,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	70,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	862,620
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	862,620
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16,820,987.56)	35,959,306.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,820,987.56)	35,959,306.28

2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	360,608,440	391,896,615
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	360,608,440	391,896,615
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,176,400	339,952,100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,176,400	339,952,100

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,385,900	11,802,875
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,385,900	11,802,875
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,098,800	22,172,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,098,800	22,172,100
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,947,340	17,969,540
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,947,340	17,969,540
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	355,543,640	391,896,615
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,543,640	391,896,615
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,543,640	390,442,595
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,882,800	255,521,317
210101	Үндсэн цалин	151,659,000	167,286,746
210102	Нэмэгдэл	55,501,800	68,171,000
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000	5,100,211
210104	Урамшуулал	12,178,000	14,963,360
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,110,400	35,044,200
210201	Тэтгэврийн даатгал	19,115,000	24,255,300
210202	Тэтгэмжийн даатгал	2,248,800	2,595,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799,100	2,076,700
210204	Ажилгүйдлийн даатгал	449,800	924,600
210205	Эрүүл мэндийн даатгал	4,497,700	5,191,700
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,146,200	21,195,323
210301	Гэрэл, цахилгаан	1,917,000	1,968,653
210302	Түлш, халаалт	10,782,800	19,026,670
210303	Цэвэр, бохир ус	446,400	200,000
2104	Хангамж, бараа материалын зардал	23,388,613.20	25,658,200
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	3,524,200
210402	Тээвэр, шатахуун	16,588,613.20	17,475,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	2,222,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	2,435,700
2105	Нормативт зардал	35,230,183.40	37,882,889
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,775,000	27,419,659
210502	Хоол, хүнс	6,842,133.40	7,505,730
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,613,050	2,957,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,106,100	3,374,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,153,500	2,627,200
210604	Урсгал засвар	952,600	747,300
2107	Томилолт, зочны зардал	1,400,000	545,200
210702	Дотоод албан томилолт	1,400,000	545,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,819,443.40	6,673,866
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,470,943.40	5,663,366
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	270,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500	335,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,459,900	4,547,100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,459,900	4,547,100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,454,020
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,454,020
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,454,020
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,064,800	=
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,064,800	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,064,800	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,064,800	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,064,800)	=

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(123,144,448.43)	346,363,893.63
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(123,144,448.43)	346,363,893.63
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(123,144,448.43)	346,363,893.63
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(123,144,448.43)	346,363,893.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(123,144,448.43)	346,363,893.63
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	35,959,306.28	35,959,306.28
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,833,500	359,222,540	383,682,500	379,231,120
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,833,500	359,222,540	383,182,500	379,231,120

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,882,800	224,882,800	257,573,700	255,521,317
210101	Үндсэн цалин	151,659,000	151,659,000	168,974,200	167,286,746
210102	Нэмэгдэл	55,501,800	55,501,800	66,158,100	68,171,000
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000	5,544,000	5,544,000	5,100,211
210104	Урамшуулал	12,178,000	12,178,000	16,897,400	14,963,360
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,110,400	28,110,400	34,772,500	35,044,200
210201	Тэтгэврийн даатгал	19,115,000	19,115,000	24,469,600	24,255,300
210202	Тэтгэмжийн даатгал	2,248,800	2,248,800	2,575,700	2,595,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799,100	1,799,100	2,060,600	2,076,700
210204	Ажилгүйдлийн даатгал	449,800	449,800	515,100	924,600
210205	Эрүүл мэндийн даатгал	4,497,700	4,497,700	5,151,500	5,191,700
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,146,200	13,146,200	21,219,500	21,195,323
210301	Гэрэл, цахилгаан	1,917,000	1,917,000	2,051,200	1,968,653
210302	Түлш, халаалт	10,782,800	10,782,800	18,621,900	19,026,670
210303	Цэвэр, бохир ус	446,400	446,400	546,400	200,000
2104	Хангамж, бараа материалын зардал	25,002,400	23,388,613	25,242,400	25,658,200
210401	Бичиг хэрэг	2,300,000	2,300,000	2,300,000	3,524,200
210402	Тээвэр, шатахуун	18,202,400	16,588,613	18,202,400	17,475,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	2,000,000	2,240,000	2,222,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	2,500,000	2,500,000	2,435,700
2105	Нормативт зардал	38,775,000	35,230,183	25,976,000	26,671,414
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,775,000	26,775,000	15,518,500	16,208,184
210502	Хоол, хүнс	8,500,000	6,842,133	7,500,000	7,505,730
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000	1,613,050	2,957,500	2,957,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,952,600	4,952,600	3,579,800	3,374,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000	4,000,000	2,627,200	2,627,200
210604	Урсгал засвар	952,600	952,600	952,600	747,300
2107	Томилолт, зочны зардал	1,400,000	1,400,000	722,800	545,200
210702	Дотоод албан томилолт	1,400,000	1,400,000	722,800	545,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,123,300	21,670,943	8,305,000	6,673,866
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,923,300	20,470,943	7,200,000	5,663,366
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000	200,000	270,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	300,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	80,000	80,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-	25,000	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000	1,000,000	500,000	335,500

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,440,800	6,440,800	5,790,800	4,547,100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,440,800	6,440,800	5,790,800	4,547,100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	500,000	-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	500,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	500,000	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,833,500	359,222,540	383,682,500	379,231,120
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	329,176,400	329,176,400	339,952,100	339,089,480
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,176,400	329,176,400	339,952,100	339,089,480
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,098,800	14,098,800	22,172,100	22,172,100
132001	Орон нутгийн төсвөөс		-	22,172,100	22,172,100
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	14,098,800	14,098,800		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,558,300	15,947,340	21,558,300	17,969,540
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,558,300	15,947,340	21,558,300	17,969,540
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	22	22
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	16	16
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
620004	Гэрээт ажилтан	4	4	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	25	22	22
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16	16	16	16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	5	5	5
650010	Гэрээт ажилтан				
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4	4	1	1

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,900	11,802,875
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,900	11,802,875
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,900	11,211,475
2105	Нормативт зардал	-	11,211,475
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	11,211,475
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,900	-

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,900	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	591,400
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		591,400
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,900	11,802,875
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,900	11,802,875
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,900	11,802,875

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч их эмч М.Хөхнохой танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, өглөг, НБББББичиг, өглөг, санхүүжилт, Шилэн данс хөтлөлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 21-нээс 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дөргөн сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлүүлэгчийн эрх, хэрэгцээг хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх, ард иргэдэд чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бий болгох” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл нь төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх байдлаар тодорхойлжээ.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дөргөн сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 340790.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3407.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 449121.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4491.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36427.2 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	962.4	2,301.4	1,339.0
Бараа материал	27,884.3	41,182.8	13,298.5
Үндсэн хөрөнгө	319,282.2	341,071.9	21,789.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	348,128.9	384,556.1	36,427.2
Богино хугацаат өр төлбөр	1,765.1	2,232.9	467.8
Цэвэр хөрөнгө, өмч	346,363.8	382,323.2	35,959.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	348,128.9	384,556.1	36,427.2

Авлага дансны үлдэгдэл 2301.4 мянган төгрөг болж 1339.0 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь өмнөх оны авлагыг барагдуулаагүй тайлант оны эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас 591.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой авлага нэмэгджээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 41182.7 мянган төгрөг болж 13298.5 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын үлдэгдэл 9150.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	27,884.30
2	Нэмэгдсэн	79,735.90
2.1	Худалдан авсан	68,609.30
2.2	Хандиваар	11,126.60
3	Хасагдсан	66,437.50
3.1	Худалдсан, зарцуулсан	66,437.50
4	Эцсийн үлдэгдэл	41,182.70

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 440542.6 мянган төгрөг, оны эцэст 488951.9 мянган төгрөг болж 48409.4 мянган төгрөгөөр өссөн нь Бейлги улсын буцалтгүй тусламжаар алсын зайн оношилгооны тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр компьютер болон тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	440,542.6
2	Нэмэгдсэн	48,409.3
2.1	Худалдан авсан	2,310.8
2.2	Хандиваар	46,098.5
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	488,951.9
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	121,260.3
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	26,619.7
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	147,880.0
11	Үлдэгдэл өртөг	341,071.9

Өр төлбөр оны эхэнд 1765.1 мянган төгрөг оны эцэст 2232.9 мянган төгрөг болж 467.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 382323.2 мянган төгрөг болж 35959.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 35959.3 мянган төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

Дэргэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 83249.3 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 83249.4 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 10775.7 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 8073.3 мянган төгрөгөөр орон нутгийн санхүүжилт, нэмэлт орлого 10417.0, ЭМДС-аас авах санхүүжилт 2022.2, үнэ төлбөргүй орлого 51961.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	379,971.2	449,121.8	83,249.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,264.0	57,225.2	51,961.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,176.4	339,952.1	10,775.7
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,098.8	22,172.1	8,073.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,385.9	11,802.9	10,417.0
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	14,098.8		
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,947.3	17,969.5	2,022.2

Нийт зардал өмнөх оноос 30469.0 мянган төгрөгөөр буюу 8 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус өссөн, хангамж бараа материалын зардал, нормативт, тогтмол болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, ЭМДС-аас авах санхүүжилтээ авч чадаагүйтэй холбоотой байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		382,693.5	413,162.5	30,469.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,882.8	258,009.6	33,126.8
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	28,039.0	33,592.5	5,553.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,954.2	22,171.3	8,217.1
2104	Хангамж, бараа материалын зардал	25,002.4	24,366.0	(636.4)
2105	Нормативт зардал	47,055.8	40,883.4	(6,172.4)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	952.6	450.0	(502.6)
2107	Томилолт, зочны зардал	1,400.0	350.0	(1,050.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	11,745.5	1,757.8	(9,987.7)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,661.2	30,649.3	988.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		932.6	932.6

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 405972.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 405972.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 383682.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 339952.1 мянган төгрөгийг тусгай шилжүүлгийн санхүүжилтээс, 22172.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМД-ын сангаас 21558.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай шилжүүлгийн санхүүжилтээс 339952.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22172.1 санхүүжилт, ЭМД-ын сангаас 17969.5 мянган төгрөг авч, нийт 380093.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 379231.1 мянган төгрөгийг зарцуулж 862.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, ЭМДС-аас авах санхүүжилтийг 3588.8 мянган төгрөгөөр санхүүжилтээ бүрэн авч чадаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 379231.1 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 1780.7, тогтмол зардал 24.2, томилолтын зардал 177.6, бараа үйлчилгээний зардал 1243.7, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1631.1, эд хогшил, урсгал засварын зардал 205.3, урсгал шилжүүлэг 500.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 4451.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 3588.8 мянган төгрөгөөр ЭМДС-аас авах санхүүжилтээ бүрэн авч чадаагүйтэй холбоотой байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,082.4

80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	1,369.0
	ДҮН	4,451.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар ЭМГ-аас эмийн зардлын санхүүжилт 11211.5, сорьц тээвэр шатахуунд 39.4, аймгийн Засаг даргын хөрөнгөөс 552.2 бүгд 11802.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11211.5 мянган төгрөгийн эмийн зардалд зарцуулж, оны эцэст сумын ерөнхий орлогын дансанд 591.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс, хугацаандаа оруулсан 125 мэдээллийг оруулсан, 11 хугацаа хоцроосон мэдээлэл байршуулж, Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт данснаас 7300.0 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн санд эмийн үнэ төлсөн ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,000.0	1	1,000.0	-	-	100
Зөвлөмж	2				2	-	-
Нийт дүн	3	1,000.0	1	1,000.0	2	-	33.3

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52145.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5185.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 26875.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, хүргүүлээ.

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн программд бараа материалыг зарлагадахдаа зардлын кодыг буруу сонгон 1176.1 мянган төгрөгийг бүртгэсэн,

2. Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого 552.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
3. Өглөг 552.20 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
4. Тайлант үеийн үр дүнг 2905.7 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад залруулга хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 5185.8 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 26875.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 26875.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгасан эм, боох материалыг 9150.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тусгасан ч бодитой оршин буйг нотлох боломжгүй жилийн эцэст эм ороох боох материалд тооллого хийгээгүй, завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,
2. Тайлант онд нийт 17725.8 мянган төгрөгийн шатахуун худалдан авч шатахууны нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, алсын дуудлагын журналтай тулгахад дуудлагын журналд бүртгэлгүй дуудлагад шатахуун олгосон, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Эрх ба үүрэг, Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 20083.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх нь асуудалгүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сумын ЭЭС-тай тооцоо нийлээгүй, 1143.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй санхүүгийн тайлан дахь өглөгийг бодитойг нотлох боломжгүй дутагдал илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлангийн бодит байдалд алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , " 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, тооллого хийж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,

Байгууллагаас өгсөн хариу: Хүлээн зөвшөөрсөн.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Эмч ажилчдыг илүү цагийн бүртгэл хөтлөөгүй, анхан шатны баримтгүй, батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл зэрэгт нийт 6649.0 мянган төгрөгийг олгосон дутагдал байна.

2.2. Эрсдэл: Төсөв хэтрэх, эдийн ангилал зөрчих

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг мөрдөх, илүү цагийн журнал бүртгэх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Бараа материалын бүртгэлд байгаа 46 нэр төрлийн 8702.5 мянган төгрөгийн материал нь тухайн ондоо зарцуулсныг тайланд үлдэгдлээр тусгаж, одоог хүртэл үлдэгдлээр тусгагдаж байгаа ч бодитоор оршин байхгүй зөрчил илэрлээ.

3.2. Эрсдэл: Бараа материал дутах, тайлан буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг мөрдөн, өмч хамгаалах зөвлөлийг томилон ажиллуулах,

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Санхүүжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: ЭМДС-аас авах өдрийн эмчилгээний 3588.8 мянган төгрөгийн зардлыг нэхэмжилж аваагүй, хариуцсан ажилтан мэдээллээ бүрэн гаргуулан хүргүүлээгүйгээс санхүүжилтээ бүрэн аваагүй зөрчил дутагдал илэрлээ.

4.2. Эрсдэл: Санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байх, ажлын хариуцлага алдах, өр төлбөр нэмэгдэх, ажилчдад үр чадварын нэмэгдэл олгохгүй байх

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", ЭМДҮЗ-ийн 2019 оны 28 дугаар тогтоол заасны дагуу "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ"-ний заалтуудыг мөрдөн ажиллах,

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Өмнөх СТА-аар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББичиг боловсруулан батлуулан мөрдөн ажиллах зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй байна.

5.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан дахь тоо мэдээллийн буруу илэрхийлэгдэх,

5.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөн ажиллах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

6. Шилэн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans.gov.mn цахим сайтад 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт данснаас эмийн үнэ төлсөн зарлагыг мэдээлээгүй байна.

6.2. Эрсдэл: Мэдээллийн ил тод мэдээлээгүй байх, мэдээлэл дутуу байршуулах

6.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;" гэсэн заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв мэдээлэх

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/76/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дөргөн сумын Эрүүл мэндийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайланд зарим материалыг зарлагдахдаа эдийн засгийн буруу сонгосон	1176.1	Залруулга хийх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	М.Хөхнохой, , О.Анхцэцэг
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого дутуу, өр төлбөр зөрүүтэй илэрхийлсэн	1104.0	Залруулга хийх		
3	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	2905.7	Залруулга хийх		
5	Санхүүгийн тайланд тусгасан эм, боох материалыг 9150.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тусгасан ч бодитой оршин буйг нотлох боломжгүй жилийн эцэст эм ороох боох материалд тооллого хийгээгүй, завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	9150.0	Албан шаардлага өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	М.Хөхнохой, , О.Анхцэцэг
6	Тайлант онд нийт 17725.8 мянган төгрөгийн шатахуун худалдан авч шатахууны нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, алсын дуудлагын журналтай тулгахад дуудлагын журналд бүртгэлгүй дуудлагад шатахуун олгосон, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй	17725.8	Албан шаардлага өгөх		
7	Сумын ЭЭС-тай тооцоо нийлээгүй, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй санхүүгийн тайлан дахь өглөгийг бодитойг нотлох боломжгүй	1143.5	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	М.Хөхнохой, , О.Анхцэцэг
8	Эмч ажилчдыг илүү цагийн бүртгэл хөтлөөгүй, анхан шатны баримтгүй, батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон	6649.0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	М.Хөхнохой, , О.Анхцэцэг
9	Бараа материалын бүртгэлд байгаа 46 нэр төрлийн материалыг тухайн ондоо зарцуулсныг тайланд үлдэгдлээр тусгаж, одоог хүртэл үлдэгдлээр тусгагдаж байгаа ч бодитоор оршин байхгүй зөрчил илэрлээ.	8702.5	Зөвлөмж өгөх		М.Хөхнохой, , О.Анхцэцэг
10	ЭМДС-аас авах өдрийн эмчилгээний зардлыг нэхэмжилж аваагүй, хариуцсан ажилтан мэдээллээ бүрэн гаргуулан хүргүүлээгүйгээс санхүүжилтээ бүрэн аваагүй	3588.8	Зөвлөмж өгөх		М.Хөхнохой, , О.Анхцэцэг

11	Өмнөх СТА-аар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББичиг боловсруулан батлуулан мөрдөн ажиллах зөвлөмж өгөгдсөн хэрэгжилт хангалтгүй		Зөвлөмж өгөх		М.Хөхнохой , О.Анхцэцэг
12	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans.gov.mn цахим сайтад 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт данснаас эмийн үнэ төлсөн зарлагыг мэдээлээгүй		Зөвлөмж өгөх		М.Хөхнохой , О.Анхцэцэг
ДҮН		52145.4			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОВД АЙМАГ ДАХЬ Т



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ЭМЧ М.ХӨХНОХОЙ ТАНАА

2021-02-25 № 4/124
танай _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар үр дүн, хэрэгжилт, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайлан дахь өр төлбөр болон эм ороох боох материалын үлдэгдлийн тоо мэдээлэл бодит бус, эм болон шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020626

ӨРИЙН АУДИТЫН ГАЗАР